



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Шийдвэрийг эс батламжлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 3.6-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

“Бадрах энерги” ХХК-ийн 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол нь Цөмийн энергийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг авахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргасан, тус хурлын шийдвэрт заасан өрийг хувьцаагаар солих аргаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмж хувьцаа гаргах хэлбэрээр нэмэгдүүлсэн нь УИХ-ын 2025 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоол, Цөмийн энергийн комиссын 2025 оны 03 дугаар тогтоолын хүрээнд хийсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байгаа тул эс батламжилсугай.

ДАРГА



Г.ДАМДИННЯМ

1725070018